

Article

Relationship Between Emotion Recognition Ability and Receptive Vocabulary Skills in Children Aged 4–5 Years

Enkhbayar Batsaikhan^{1*}, Enkhjin Munkhbaatar²

¹ Department of Psychology and Social Work, Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

² Department of Psychology and Social Work, Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: b.enkhbayar@otgontenger.edu.mn



<https://orcid.org/0000-0002-3165-6665>

Received: 20 March 2026. Accepted: 21 May 2026. Published online: 15 June 2026

Abstract

Early childhood is a critical developmental stage during which cognitive, language, social, and emotional abilities rapidly develop. The purpose of this study was to examine the relationship between emotion recognition ability and receptive vocabulary among preschool children aged 4–5. The study involved 45 preschool children. Denham's Affective Knowledge Test (AKT) and the Peabody Picture Vocabulary Test (PVT) were used to assess children's emotion recognition and receptive language abilities. Descriptive statistics and Pearson correlation analysis were conducted to analyse the data. The results indicated a strong positive correlation between emotion recognition ability and receptive vocabulary ($r = .732, p < .01$). This suggests that children with better emotional understanding tend to have stronger language comprehension skills. The findings highlight the importance of supporting both emotional and language development in early childhood education. The study contributes to understanding the developmental relationship between emotional intelligence and language ability among preschool children in Mongolia.

Keywords

emotional intelligence, emotion recognition, receptive vocabulary, preschool children, early childhood development



© 2026, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator. <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

4–5 настай хүүхдийн сэтгэл хөдлөлийг таних чадвар болон үг хүлээн авах чадварын холбоо хамаарлыг судалсан нь

Батсайханы Энхбаяр¹, Мөнхбаатарын Энхжиган²

¹ Сэтгэл судлал, нийгмийн ажлын тэнхим, Хүмүүнлэгийн сургууль, Отгонтэнгэр их сургууль, Улаанбаатар хот, Монгол улс

²Магистрын оюутан, сэтгэл судлал, нийгмийн ажлын тэнхим, Хүмүүнлэгийн сургууль, Отгонтэнгэр их сургууль, Улаанбаатар хот, Монгол улс

Удиртгал

Сургуулийн өмнөх нас нь хүний хөгжлийн хамгийн чухал үе шатны нэг бөгөөд энэ үед танин мэдэхүй, хэл яриа, нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн чадварууд эрчимтэй хөгждөг. Судалгаагаар хүүхдийн тархины хөгжлийн 80–90 хувь нь 5 наснаас өмнө бүрэлддэг бөгөөд энэ үеийн хөгжлийн чанар нь цаашдын суралцах чадвар, зан төлөв, нийгэмшихүйд урт хугацаанд нөлөөлдөг болохыг тогтоосон байдаг (Shonkoff & Phillips, 2000). Сүүлийн жилүүдэд хүүхдийн хөгжлийг судлахад сэтгэл хөдлөлийн оюун ухааны асуудал чухал байр суурь эзлэх болсон. Сэтгэл хөдлөлийн оюун ухаан нь хувь хүн өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таних, ойлгох, зохицуулах чадварын цогц ойлголт бөгөөд нийгмийн харилцаа болон суралцах үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг (Mayer & Salovey, 1997). Судалгаагаар сэтгэл хөдлөлийн оюун ухаан өндөртэй хүүхдүүд нийгмийн харилцаанд илүү амжилттай оролцож, сургалтын орчинд дасан зохицох чадвар өндөр байдаг нь тогтоогдсон (Denham et al., 2012). Үүнтэй зэрэгцэн хэл ярианы хөгжил нь хүүхдийн танин мэдэхүй, харилцаа, нийгмийн дасан зохицолд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа үгийг ойлгох чадвар нь хүүхдийн унших, бичих чадварын суурь болж, цаашдын академик амжилтыг урьдчилан таамаглах чухал үзүүлэлт болдог (Snow et al., 1998). Олон улсын судалгаагаар сэтгэл хөдлөлийн оюун ухаан болон хэл ярианы хөгжил нь харилцан уялдаатай хөгждөг болохыг тогтоосон (Izard et al., 2001). Гэвч Монгол Улсад сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл хөдлөлийн оюун ухаан болон хэл ярианы хөгжлийн уялдаа холбоог эмпирик аргаар судалсан судалгаа харьцангуй хомс хэвээр байна.

Иймээс энэхүү судалгааны зорилго нь 4–5 настай хүүхдийн сэтгэл хөдлөлийг таних чадвар болон үг хүлээн авах чадварын хоорондын холбоо хамаарлыг тодорхойлох явдал юм.

Results and Discussion

Энэхүү судалгаанд сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй 4–5 настай 45 хүүхдийн сэтгэл хөдлөлийг таних чадвар болон үг хүлээн авах чадварын хөгжлийн түвшинг үнэлж, тэдгээрийн хоорондын хамаарлыг статистикийн аргаар тодорхойлсон. Судалгаанд Денхамын сэтгэл хөдлөлийн мэдлэгийн тест (АКТ) болон Пибодигийн зурагт үгийн сангийн тест (PVT)-ийг ашиглан өгөгдөл цуглуулж, SPSS программ ашиглан статистикийн боловсруулалт хийсэн.

1. Сэтгэл хөдлөлийг таних болон үг хүлээн авах чадварын статистик үзүүлэлт

Хүснэгт 1. Сэтгэл хөдлөлийг таних ба үг хүлээн авах чадварын статистик үзүүлэлт
(N = 45)

Хувьсагч	Min–Max	Mean	SE	SD
Сэтгэл хөдлөлийг таних чадвар	0–40	28.51	1.49	10.01
Үг хүлээн авах чадвар	1–40	31.73	1.48	9.95

Хүснэгт 1-ээс харахад судалгаанд оролцсон хүүхдүүдийн сэтгэл хөдлөлийг таних чадварын дундаж оноо 28.51 байна. Энэ нь хүүхдүүдийн ихэнх нь баярлах, гуних, уурлах, айх зэрэг үндсэн сэтгэл хөдлөлийг ялган таних чадвартай болсныг илтгэж байна. Гэсэн хэдий ч стандарт хазайлт 10.01 байгаа нь хүүхдүүдийн сэтгэл хөдлөлийг таних чадварын түвшин харилцан адилгүй байгааг харуулж байна.

Харин үг хүлээн авах чадварын дундаж оноо 31.73 байгаа нь оролцогч хүүхдүүдийн хэл ярианы ойлгох чадвар харьцангуй өндөр түвшинд хөгжсөн байгааг илтгэнэ. Үг хүлээн авах чадварын стандарт хазайлт 9.95 байгаа нь оролцогч хүүхдүүдийн хэл ярианы хөгжлийн түвшин тодорхой хэмжээгээр ялгаатай байгааг харуулж байна.

Ерөнхийд нь авч үзвэл судалгаанд оролцсон хүүхдүүдийн үг хүлээн авах чадварын дундаж оноо сэтгэл хөдлөлийг таних чадвараас харьцангуй өндөр байгаа нь энэ насанд хэл ярианы ойлгох чадвар тодорхой хэмжээгээр хөгжсөн боловч сэтгэл хөдлөлийн танин мэдэхүй харьцангуй шаталсан байдлаар хөгжиж байгааг илтгэж байна.

2. Хувьсагчдын хоорондын хамаарлын шинжилгээ

4–5 настай хүүхдийн сэтгэл хөдлөлийг таних чадвар, үг хүлээн авах чадвар болон бусад хувьсагчдын хоорондын хамаарлыг Pearson корреляцийн шинжилгээгээр тодорхойлсон.

Хүснэгт 2. Хувьсагчдын хоорондын корреляцийн шинжилгээ (N = 45)

Хувьсагч	1	2	3	4	5
1. Сэтгэл хөдлөлийг таних чадвар	1	.732**	.237	.075	.212
2. Үг хүлээн авах чадвар	.732**	1	.106	-.284	.311*
3. Хүйс	.237	.106	1	.179	.012
4. Нас	.075	-.284	.179	1	-.517**
5. Хэвшил	.212	.311*	.012	-.517**	1

**p < .01

*p < .05

Хүснэгт 2-оос харахад сэтгэл хөдлөлийг таних чадвар болон үг хүлээн авах чадварын хооронд статистикийн ач холбогдол бүхий хүчтэй эерэг хамаарал ($r = .732$, $p < .01$) илэрсэн байна. Энэ нь сэтгэл хөдлөлийн мэдлэг өндөртэй хүүхдүүдийн хэл ярианы ойлгох чадвар илүү сайн байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, хүүхэд сэтгэл хөдлөлийг таних, ялган ойлгох чадвар өндөр байх тусам үгийн утгыг ойлгох, хэл ярианы мэдээллийг хүлээн авах чадвар илүү хөгжсөн байх боломжтойг харуулж байна.

Мөн үг хүлээн авах чадвар болон хүүхдийн хэвшлийн хооронд статистикийн ач холбогдол бүхий эерэг хамаарал ($r = .311$, $p < .05$) илэрсэн нь хүүхдийн өдөр тутмын зан үйл, тогтсон дадал хэвшил нь хэл ярианы хөгжлийн тодорхой хүчин зүйл болж болохыг илтгэнэ.

Харин нас болон хэвшлийн хооронд статистикийн ач холбогдол бүхий сөрөг хамаарал ($r = -.517$, $p < .01$) илэрсэн нь хүүхдийн хөгжлийн явцад зан үйлийн хэвшил өөрчлөгдөх, хөгжлийн динамик шинжтэй болохыг харуулж байна.

Хэлэлцүүлэг

Судалгааны үр дүнгээс харахад сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл хөдлөлийг таних чадвар болон хэл ярианы ойлгох чадвар хоорондоо нягт холбоотой хөгждөг болох

нь тогтоогдлоо. Ялангуяа сэтгэл хөдлөлийг таних чадвар өндөртэй хүүхдүүд үг хүлээн авах чадварын хувьд илүү сайн үзүүлэлттэй байсан нь сэтгэл хөдлөлийн ойлголт болон хэл ярианы ойлгох чадвар харилцан уялдаатай хөгждөг болохыг харуулж байна.

Энэхүү үр дүн нь Denham (1998), Izard (2001) болон Blair & Raver (2015) нарын судалгааны үр дүнтэй нийцэж байна. Тэдний судалгаанд хүүхдийн сэтгэл хөдлөлийг таних, нэрлэх чадвар нь хэл ярианы хөгжил, нийгмийн харилцаа болон суралцах үйл ажиллагаанд чухал нөлөөтэй болохыг тогтоосон байдаг.

Хүүхэд сэтгэл хөдлөлийг таних, ойлгох чадвартай болохын тулд тухайн сэтгэл хөдлөлийг нэрлэх, тайлбарлах хэл ярианы чадвар шаардлагатай байдаг. Нөгөө талаас хэл ярианы хөгжлийн түвшин өндөр байх тусам хүүхэд бусдын сэтгэл хөдлөлийг илүү нарийн ойлгох боломжтой болдог. Иймээс сэтгэл хөдлөлийн оюун ухаан болон хэл ярианы хөгжил нь харилцан бие биенээ дэмжин хөгждөг гэж үзэж болно.

Иймээс сургуулийн өмнөх боловсролын орчинд хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжихийн зэрэгцээ сэтгэл хөдлөлийг таних, ойлгох, илэрхийлэх чадварыг хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлэх нь хүүхдийн цогц хөгжлийг дэмжихэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаагаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдаж буй 4–5 настай хүүхдийн сэтгэл хөдлөлийг таних чадвар болон үг хүлээн авах чадварын хөгжлийн түвшинг үнэлж, эдгээр хувьсагчдын хоорондын харилцан хамаарлыг эмпирик судалгаанд тулгуурлан тодорхойллоо. Судалгааны үр дүнгээс харахад сэтгэл хөдлөлийг таних чадвар болон үг хүлээн авах чадварын хооронд статистикийн ач холбогдол бүхий хүчтэй эерэг хамаарал ($r = .732$, $p < .01$) илэрсэн нь сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл хөдлөлийн оюун ухаан болон хэл ярианы хөгжил харилцан уялдаатай хөгждөг болохыг харуулж байна.

Мөн судалгааны үр дүнгээс үг хүлээн авах чадвар болон хүүхдийн зан үйлийн хэвшлийн хооронд статистикийн ач холбогдол бүхий эерэг хамаарал ($r = .311$, $p < .05$) илэрсэн нь хүүхдийн өдөр тутмын орчин, зан үйлийн дадал хэвшил нь хэл ярианы хөгжлийн тодорхой хүчин зүйл байж болохыг илтгэнэ. Харин нас

болон зан үйлийн хэвшлийн хооронд илэрсэн сөрөг хамаарал ($r = -.517$, $p < .01$) нь хүүхдийн хөгжлийн явцад зан үйлийн хэвшил тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж, хөгжлийн динамик шинжтэй байдгийг харуулж байна.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сэтгэл хөдлөлийг таних чадвар болон хэл ярианы ойлгох чадварт хүйсийн ялгаа статистикийн ач холбогдолтойгоор илрээгүй нь сургуулийн өмнөх насанд эдгээр чадварууд хүйсээс үл хамааран харьцангуй төстэй түвшинд хөгжиж байгааг харуулж байна.

Эдгээр үр дүн нь сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл хөдлөлийн оюун ухаан болон хэл ярианы хөгжил хоорондоо нягт уялдаатай хөгждөг болохыг онцолсон Denham, Izard, Blair & Raver зэрэг судлаачдын өмнөх судалгааны дүгнэлттэй нийцэж байна. Иймээс сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчинд хүүхдийн хэл ярианы хөгжлийг дэмжихийн зэрэгцээ сэтгэл хөдлөлийг таних, ойлгох, илэрхийлэх чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдаа холбоотойгоор хэрэгжүүлэх нь хүүхдийн танин мэдэхүй, нийгэмшихүй, суралцах бэлэн байдлыг дэмжихэд чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна.

Цаашид сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэл хөдлөлийн оюун ухаан, хэл яриа болон нийгэмшихүйн хөгжлийн харилцан уялдааг илүү өргөн хүрээтэй түүвэр дээр судлах, мөн гэр бүлийн орчин, сургалтын орчны нөлөөллийг хамтад нь авч үзэх судалгаа хийх шаардлагатай гэж үзэж байна.

References

- Bar-On, R. (1997). *The emotional quotient inventory (EQ-i): Technical manual*. Multi-Health Systems.
- Blair, C., & Raver, C. C. (2015). School readiness and self-regulation: A developmental psychobiological approach. *Annual Review of Psychology*, 66, 711–731.
<https://doi.org/10.1146/annurev-psych-010814-015221>
- Denham, S. A. (1998). *Emotional development in young children*. Guilford Press.
- Denham, S. A., Bassett, H. H., & Wyatt, T. (2012). The socialization of emotional competence. *Developmental Psychology*, 48(2), 375–386.
<https://doi.org/10.1037/a0026606>

- Goleman, D. (1995). *Emotional intelligence: Why it can matter more than IQ*. Bantam Books.
- Izard, C. E., Fine, S., Schultz, D., Mostow, A., Ackerman, B., & Youngstrom, E. (2001). Emotion knowledge as a predictor of social behavior and academic competence in children. *Psychological Science*, 12(1), 18–23. <https://doi.org/10.1111/1467-9280.00304>
- Mayer, J. D., & Salovey, P. (1997). What is emotional intelligence? In P. Salovey & D. Sluyter (Eds.), *Emotional development and emotional intelligence: Educational implications* (pp. 3–31). Basic Books.
- Mayer, J. D., Salovey, P., & Caruso, D. R. (2004). Emotional intelligence: Theory, findings, and implications. *Psychological Inquiry*, 15(3), 197–215. https://doi.org/10.1207/s15327965pli1503_02
- Paul, R., & Norbury, C. F. (2012). *Language disorders from infancy through adolescence: Listening, speaking, reading, writing, and communicating* (4th ed.). Elsevier.
- Shonkoff, J. P., & Phillips, D. A. (2000). *From neurons to neighborhoods: The science of early childhood development*. National Academy Press.
- Snow, C. E., Burns, M. S., & Griffin, P. (1998). *Preventing reading difficulties in young children*. National Academy Press.
- Thorndike, E. L. (1920). Intelligence and its uses. *Harper's Magazine*, 140, 227–235.
- Wechsler, D. (1958). *The measurement and appraisal of adult intelligence* (4th ed.). Williams & Wilkins.
- Enkhbayar, B. (2019). *Оюутан бие хүний сэтгэл хөдлөлийн оюун ухааны судалгаа* (Doctoral dissertation). Ulaanbaatar. (in Mongolian)
- Enkhbayar, B. (2020). *Ухаалаг сэтгэл хөдлөл*, Ulaanbaatar. (in Mongolian)